



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/384/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ш.Мөнхжаргал Утас: 325093 Цахим хаяг: Munkhjargalsh@audit.gov.mn</p>
---	--

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 01. 23 № 28
танай _____ -ны № _____ -Т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ДАРГА
Ц.МӨНХЗУЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 140 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

D:\Desktop\2024\Word\Явсан биеийн\2024.02.23 CHD Pro.docx

002321382

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>51,390,344.15</u>	<u>47,281,272.15</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,640,766.90	23,540,766.90
3121	Төгрөг	32,640,766.90	23,540,766.90
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	32,640,766.90	23,540,766.90
33	АВЛАГА	00.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,749,577.25	23,740,505.25
354	Хангамжийн материал	18,749,577.25	23,740,505.25
35410	Бичиг хэргийн материал	5,079,283.00	3,411,711.00
35440	Түлш, шатах тослох материал	450,000.00	113,600.00
35470	Бусад хангамжийн материал	13,220,294.25	20,215,194.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,433,706,282.87</u>	<u>1,397,672,209.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,433,706,282.87	1,397,672,209.98
392	Биет хөрөнгө	1,432,376,282.89	1,396,722,210.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,184,697,959.00	1,183,823,574.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-89,009,018.96	-115,665,414.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	99,900,000.00	99,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,740,000.00	-49,230,000.00
39205	Машин тоног төхөөрөмж	265,592,277.09	319,977,202.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,738,795.02	-117,753,724.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	127,631,626.20	123,879,656.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-77,753,362.10	-65,017,761.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,648,000.00	18,648,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-852,403.32	-1,839,323.28
393	Биет бус хөрөнгө	1,329,999.98	949,999.94
39301	Програм хангамж	1,520,000.00	1,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-190,000.02	-570,000.06
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,485,096,627.02</u>	<u>1,444,953,482.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>32,640,766.90</u>	<u>23,540,766.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,640,766.90	23,540,766.90
413	Өглөг	00.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
414	Урьдчилж орсон орлого	32,640,766.90	23,540,766.90
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	32,640,766.90	23,540,766.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,452,455,860.12</u>	<u>1,421,412,715.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,452,455,860.12	1,421,412,715.23
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГС/	642,093,952.19	642,093,952.19

51101	Өмч: - төрийн	642,093,952.19	642,093,952.19
512	Хуримтлагдсан үр дүн	400,627,433.04	369,584,288.15
51210	Өмнөх үеийн үр дүн	390,808,243.59	400,627,433.04
51220	Тайлант үеийн үр дүн	9,819,189.45	-31,043,144.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	409,734,474.89	409,734,474.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,485,096,627.02	1,444,953,482.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,943,677,950.00	1,977,031,930.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,872,850.00	34,447,630.00
120	Нийтлэг татварын бус орлого	107,872,850.00	34,447,630.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	107,872,850.00	34,447,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,805,100.00	1,942,584,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,835,805,100.00	1,911,521,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,835,805,100.00	1,911,521,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	31,062,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	31,062,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,924,608,760.52	2,008,075,074.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,924,608,760.52	2,008,075,074.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,767,875,919.94	1,977,229,430.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,356,965,610.91	1,537,551,293.71
210101	Үндсэн цалин	868,138,991.28	867,537,366.17
210102	Нэмэгдэл	344,702,127.55	420,193,630.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,570,645.05	90,702,544.31
210104	Урамшуулал	66,553,847.03	159,117,752.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,998,648.51	187,407,879.78
210201	Тэтгэврийн даатгал	115,242,992.57	128,012,705.82
210202	Тэтгэмжийн даатгал	13,509,046.11	15,066,300.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,807,236.77	11,920,062.93
210204	Ажилгүйдлийн даатгал	2,672,815.20	2,938,057.29
210205	Эрүүл мэндийн даатгал	26,766,557.86	29,470,752.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,630,600.00	25,953,688.06
210301	Гэрэл, цахилгаан	14,253,562.00	16,663,360.44
210302	Түлш, халаалт	3,238,100.00	5,862,212.33
210303	Цэвэр, бохир ус	3,138,938.00	3,428,115.29
2104	Хангамж, бараа материалын зардал	35,597,753.00	47,092,386.46
210401	Бичиг хэрэг	20,725,409.00	27,244,948.00
210402	Тээвэр, шатахуун	6,150,000.00	5,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,997,863.00	3,069,134.46

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,724,481.00	10,218,304.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,841,650.00	6,661,099.34
210602	Тавилга	47,300.00	00.00
210604	Урсгал засвар	11,794,350.00	6,661,099.34
2107	Томилолт, зочны зардал	00.00	444,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	444,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,802,900.00	16,085,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,662,900.00	15,948,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	136,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,538,757.52	156,033,702.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,175,938.00	34,623,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,705,000.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,657,819.52	118,410,402.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,732,840.58	30,845,644.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,760,000.00	5,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,760,000.00	5,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	153,972,840.58	25,445,644.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	153,972,840.58	25,445,644.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	19,069,189.48	-31,043,144.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,250,000.03	00.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	9,250,000.03	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-9,250,000.03	00.00
5	НИЙТ ҮР ДҮН	9,819,189.45	-31,043,144.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,842,905,100.00	1,942,584,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,100,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,100,000.00	00.00
120009	Бусад орлого	7,100,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,805,100.00	1,942,584,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,835,805,100.00	1,911,521,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,835,805,100.00	1,911,521,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	31,062,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	00.00	31,062,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,818,249,400.00	1,903,755,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,818,249,400.00	1,903,755,600.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,652,071,559.42	1,863,809,955.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,356,965,610.91	1,537,551,293.71
210101	Үндсэн цалин	868,138,991.28	867,537,366.17
210102	Нэмэгдэл	344,702,127.55	420,193,630.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,570,645.05	90,702,544.31
210104	Урамшуулал	66,553,847.03	159,117,752.47
2102	Ажил олгогчоос НДШимтгэл	168,998,648.51	187,407,879.78
210201	Тэтгэврийн даатгал	115,242,992.57	128,012,705.82
210202	Тэтгэмжийн даатгал	13,509,046.11	15,066,300.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,807,236.77	11,920,062.93
210204	Ажилгүйдлийн даатгал	2,672,815.20	2,938,057.29
210205	Эрүүл мэндийн даатгал	26,766,557.86	29,470,752.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,630,600.00	25,953,688.06
210301	Гэрэл, цахилгаан	13,935,684.00	16,663,360.44
210302	Түлш, халаалт	3,238,100.00	5,862,212.33
210303	Цэвэр, бохир ус	3,456,816.00	3,428,115.29
2104	Хангамж, бараа материалын зардал	35,806,000.00	44,845,214.46
210401	Бичиг хэрэг	21,161,282.00	19,250,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,100,000.00	5,533,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,120,933.00	3,069,134.46
210405	Хог хаягдал зайлуулах, хортон устгал, ариутгал	00.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,423,785.00	16,192,480.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,814,900.00	9,455,099.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	623,000.00
210602	Тавилга	47,300.00	00.00
210604	Урсгал засвар	12,767,600.00	8,832,099.34
2107	Томилолт, зочны зардал	00.00	444,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	444,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,602,900.00	18,529,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,462,900.00	18,393,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	136,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,752,900.00	39,622,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,047,900.00	36,622,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,705,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,177,840.58	39,945,644.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,445,000.00	9,100,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,445,000.00	9,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,760,000.00	5,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,760,000.00	5,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	153,972,840.58	25,445,644.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	153,972,840.58	25,445,644.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	24,655,700.00	38,828,700.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	27,000,700.00	47,928,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,000,700.00	47,928,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,000,700.00	47,928,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,000,700.00	47,928,700.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-27,000,700.00	-47,928,700.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-2,345,000.00	-9,100,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,985,766.90	32,640,766.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,640,766.90	23,540,766.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,093,952.19	409,734,474.89	390,808,243.59	1,442,636,670.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,093,952.19	409,734,474.89	390,808,243.59	1,442,636,670.67
Тайлант үеийн үр дүн			9,819,189.45	9,819,189.45
2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	642,093,952.19	409,734,474.89	400,627,433.04	1,452,455,860.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,093,952.19	409,734,474.89	400,627,433.04	1,452,455,860.12
Тайлант үеийн үр дүн			-31,043,144.89	-31,043,144.89
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,093,952.19	409,734,474.89	369,584,288.15	1,421,412,715.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,911,521,500.00	1,895,175,855.35	16,345,644.65	99.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,911,521,500.00	1,895,175,855.35	16,345,644.65	99.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,904,771,500.00	1,880,675,855.35	24,095,644.65	98.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,554,128,100.00	1,537,551,293.71	16,576,806.29	98.93
210101	Үндсэн цалин	885,647,600.00	867,537,366.17	18,110,233.83	97.96
210102	Нэмэгдэл	560,536,500.00	420,193,630.76	140,342,869.24	74.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.00	90,702,544.31	7,241,455.69	92.61

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210104	Урамшуулал	10,000,000.00	159,117,752.47	(149,117,752)	-
210105	Гэрээт ажлын хөлс			-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,266,100.00	187,407,879.78	6,858,220.22	96.47
210201	Тэтгэврийн даатгал	132,100,900.00	128,012,705.82	4,088,194.18	96.91
210202	Тэтгэмжийн даатгал	15,541,300.00	15,066,300.96	474,999.04	96.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,433,000.00	11,920,062.93	512,937.07	95.87
210204	Ажилгүйдлийн даатгал	3,108,300.00	2,938,057.29	170,242.71	94.52
210205	Эрүүл мэндийн даатгал	31,082,600.00	29,470,752.78	1,611,847.22	94.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,142,400.00	25,953,688.06	188,711.94	99.28
210301	Гэрэл, цахилгаан	15,536,300.00	16,663,360.44	(1,127,060.44)	107.25
210302	Түлш, халаалт	6,300,000.00	5,862,212.33	437,787.67	93.05
210303	Цэвэр, бохир ус	4,306,100.00	3,428,115.29	877,984.71	79.61
2104	Хангамж, бараа материалын зардал	45,211,100.00	44,845,214.46	365,885.54	99.19
210401	Бичиг хэрэг	19,250,000.00	19,250,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,533,600.00	5,533,600.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,427,500.00	3,069,134.46	358,365.54	89.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,200,000.00	16,192,480.00	7,520.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,915,000.00	32,820,999.34	94,000.66	99.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,908,900.00	91,100.00	98.18
210602	Тавилга	19,080,000.00	19,080,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,835,000.00	8,832,099.34	2,900.66	99.97
2107	Томилолт, зочны зардал	444,000.00	444,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	444,000.00	444,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,542,000.00	18,529,980.00	12,020.00	99.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,402,000.00	18,393,500.00	8,500.00	99.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	136,480.00	3,520.00	97.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,122,800.00	33,122,800.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,122,800.00	33,122,800.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,750,000.00	14,500,000.00	(7,750,000.00)	214.81
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	9,100,000.00	(9,100,000.00)	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг			-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,750,000.00	5,400,000.00	1,350,000.00	80.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,750,000.00	5,400,000.00	1,350,000.00	80.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,911,521,500.00	1,886,075,855.35	25,445,644.65	98.67
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,911,521,500.00	1,886,075,855.35	25,445,644.65	98.67
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,911,521,500.00	1,886,075,855.35	25,445,644.65	98.67
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		32,640,766.90	(32,640,766.90)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		23,540,766.90	(23,540,766.90)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53.00	48.00	5.00	90.57
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	35.00	5.00	87.50
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,062,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		31,062,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,062,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		24,562,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,562,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		6,500,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,500,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,000,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,062,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,062,800.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 9,819.2 мянган төгрөгийн алдаа ¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмнөх оны тайлант үеийн үр дүнг тусгаагүй	1	9819.2			1	9819.24	1	9819.2				
Дүн	1	9819.2	1		1	9819.24	1	9819.24				

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,860.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийн дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн видео шторк, контентыг зардлаар бүртгэсэн	1	4,500.0					1	4,500.0				
Эзэмшиж буй барилгын газар бүртгэлд аваагүй	1	-					1	-				
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан.	1	360.0					1	360.0				
Дүн	3	4,860.0			-	-	3	4,860.0	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-